



КРЕДИТ
ББСБ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 4 сарын 13-ны өдөр

Дугаар 2020/12

Улаанбаатар хот

Журмууд шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 4 сарын 13-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн Ногдол ашгийн бодлогыг 1 дүгээр хавсралтаар, Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны журмыг 2 дугаар хавсралтаар, Эрсдэлийн үнэлгээний аргачлалыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 7 сарын 5-ны өдрийн 2019/14 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны заавар, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 7 сарын 5-ны өдрийн 2019/15 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан Ногдол ашгийн бодлогыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
3. Тогтоолын хэрэгжилтийг хангаж, журмуудын хэрэгжилтийг хангуйж ажиллахыг Гүйцэтгэх захирал Г.Тэлмэнд даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Дотоод Аудитын Хороонд үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ



АРД КРЕДИТ БСБ ХК-ИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү ногдол ашгийн журам (цаашид “Журам” гэх)-аар Ард Кредит БСБ ХК (цаашид “Компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, ногдол ашиг хуваарилахтай холбоотой шийдвэр гаргах, энэ талаарх шийдвэрийг хувьцаа эзэшигчдэд мэдээлэх, ногдол ашгийг төлөх, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Журам нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны тухай хууль, Компанийн дүрэм, зохих байгууллагаас гаргасан холбогдох дүрэм, журмуудад нийцэн бөгөөд Компани ногдол ашиг хуваарилах, төлөх ажиллагаанд дээрх хууль, дүрэм, журмуудыг мөрдлөг болгон ажиллана.

ХОЁР. НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

- 2.1 Компани нь хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг бизнесийн үйл ажиллагаанд зүй зохистой, үр ашигтай захирлан зарцуулж, тухайн жилийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд төлөх ногдол ашгийг зохистой хэмжээнд байлгах бодлогыг баримтална.
- 2.2 Компани нь дараах нөхцөлүүд бүрэн хангагдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилна. Үүнд:
 - 2.2.1 Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;
 - 2.2.2 Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх;
 - 2.2.3 Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүгдийг нь эргүүлэн авсан байх.
- 2.3 Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргана.





КРЕДИТ
ББСБ

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн
2020/12 тоот тогтоолын Хавсралт-1

- 2.4 Төлөөлөн удирдах зөвлөлөөс ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн нөхцөлд тухайн шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэж тайлагнана.
- 2.5 Төлөөлөн удирдах зөвлөлийн ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр, ногдол ашиг төлөх өдөр зэргийг тусгана.
- 2.6 Ногдол ашгийг бүрэн төлж дуусах хугацаа нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдсанаас хойш хуанлийн 60 хоногоос хэтрэхгүй байвал зохино.
- 2.7 Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь 25-аас дээш хувиар багассан тохиолдолд ногдол ашигаа төлж дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчиддээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийг бичгээр мэдэгдэх үүргийг гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ.

ГУРАВ. НОГДОЛ АШГИЙН ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ

- 3.1 ТУЗ нь ногдол ашгийг тодорхойлсон тооцооллыг тухайн жилд хэлэлцэж гаргана.

ДӨРӨВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ, ТӨЛӨХ

- 4.1 ТУЗ нь ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр буюу бүртгэлийн өдрийг тогтоох бөгөөд тухайн өдрөөр тасалбар болгосон нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн хувьцаа эзэмшигч ногдол ашиг авах эрх үүснэ.
- 4.2 Компани ногдол ашиг хуваарилаад Компанийн тухай хуулийн 46-47 дугаар зүйлд заасан нөхцөл, журмыг хангасан байна.
- 4.3 Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрт дараах зүйлсийг тусгана.

Үүнд:

- 4.3.1 Хувьцааны төрөл тус бүрээр нэгж хувьцаанд ногдох ногдол ашигийн хэмжээ;
- 4.3.2 Ногдол ашгийг олгох хугацаа;
- 4.3.3 Олгох арга, хэлбэр (эрх бүхий зуучлагчаар дамжуулах, эд хөрөнгө, бэлэн мөнгө, бусад үнэт цаасаар төлөх гэх мэт);
- 4.3.4 Бүртгэлийн өдөр;
- 4.3.5 Бусад холбогдох асуудал.

- 4.4 Ногдол ашиг олгох өдөр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдсанаас хойш 60-аас илүүгүй хоног байхаар тооцож ногдол ашиг тараах хугацааг тогтоовол зохижжтой.
- 4.5 Ногдол ашиг хуваарилах талаар мэдээллийг компани өөрийн цахим хуудсаар болон өдөр тутам хэвлэгдэж, орон даяар тараагддаг сонингоор мэдээлнэ. Мэдээлэлд нэгж хувьцаанд ногдох ногдох ашгийн хэмжээ, төлөх хугацаа; арга зам, ногдол ашгийн талаар лавлагаа авах утасны дугаар зэргийг тусгана.
- 4.6 Бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх хүртэлх хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусад шилжүүлсэн тохиолдолд уг хувьцаанд ногдох ногдол ашгийг авах эрх нь хуучин хувьцаа эзэмшигчид үлдэнэ.
- 4.7 Хувьцаа эзэмшигчдэд төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг төлбөл зохих өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгаж, ногдол ашиг төлж эхэлсэн улирал болон жилийн эцэст олгоогүй байгаа ногдол ашгийг өглөгийн бүртгэлд бүртгэнэ.

ТАВ. ТАЙЛАГНАХ

- 5.1 Компани нь ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.
- 5.2 Ногдол ашиг төлсний дараагийн улиралд энэ талаар компанийн санхүүгийн тайланда холбогдох хуульд заасны дагуу тусгана.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

- 6.1 Компани өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг хугацаанд нь төлөөгүй бол зохих ёсоор ногдол ашиг аваагүй хувьцаа эзэмшигчид учирсан хохирлыг Гүйцэтгэх удирдлага хариуцна.

АРД КРЕДИТ ББСБ ХК

